

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2019 ОНЫ 6 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2019.07.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар

Аймгийн ИТХ-ын XV хуралдаан 1 удаа, Тэргүүлэгчдийн хурал 2 удаа хуралдаж, доорхи асуудлуудыг хэлэлцлээ. Үүнд:

Аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн орлогын гүйцэтгэлийг 78 549 720 720.58 төгрөгөөр, төсвийн зарлагын гүйцэтгэлийг 78 240 571 172.02 төгрөгөөр баталж, Аймгийн 2019 оны төсөв батлах тухай 51 дүгээр тогтоолын хавсралт дахь зарим төсөл, арга хэмжээний нэршил өөрчлөх асуудлыг хэлэлцэн уг тогтоолын нэгдүгээр хавсралт дахь “Аймгийн төсвийн хөрөнгөөр 2019 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын 2.2.1 дэх арга хэмжээний нэршлийг “Сайхан суманд төрийн албан хаагчийн орон сууц худалдан авах” гэж өөрчлөн тогтоосон.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай хэлэлцээд бэлчээр хадлангийн болон тариалангийн талбайн хөрсний элэгдэл доройтлыг бууруулах, үржил шимийг хамгаалах зорилгоор малын тоо толгойг цөөрүүлэн малыг эдийн засгийн эргэлтэнд оруулан эрчимжүүлж, бэлчээрийн даацад тохирсон мал аж ахуйг хөгжүүлэх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай тогтоолыг баталж, Сайхан сумын Гавшгай 2-р багийг хуваан Дөмбөн 4 дүгээр багийг шинээр нэмж байгуулахаар шийдвэрлэж, Ерөө сумын 3-р баг Бугант тосгоныг сум болгох саналыг Монгол Улсын Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэв. Мөн Зарим газар нутгийг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг хэлэлцэн 4 сумын 14 байршлын 332.13 га талбайн газрыг бичил уурхайн зориулалтаар 5 жилийн хугацаатайгаар аймгийн тусгай хэрэгцээнд авахаар тогтоолыг баталлаа.

Тэргүүлэгчдийн хурлаар хурлаар:

-2019 онд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, нөхөн сэргээлтийн өдрийг зарлах тухай болон 2019 онд ойгоос бэлтгэх модны хэмжээнд нэмэлт оруулан тогтоол гаргалаа.

-Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Шаамар сум дахь Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн үүсч хөгжсөний 60 жилийн ойг тохиолдуулан тус төвийг “Алтан гадас” одонгоор, Сэлэнгэ аймагт барилгын мэргэжлийн байгууллага үүсч байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан барилгын үйлдвэрлэлийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын ахмад настан Сэнгийн Мөнхтоогог Гавьяат барилгачин цолоор, мөн аймаг орноо хөгжүүлэх үйлсэд хүч хөдөлмөрөө зориулан ажилласан Сүхбаатар сумын ахмад настан, боловсролын ухааны доктор, түүхч Өөлдийн Бавууг Гавьяат эдийн засагч цолоор, Сүхбаатар сумын ахмад настан, ахмад багш Зундуйн Баасанчулууныг Гавьяат багш цолоор, Сүхбаатар сумын ахмад настан, ахмад багш Батдондогийн Далайсүрэнг Гавьяат багш цолоор, Хушаат сумын “Хайрхан оргил уул” ХХК-ий захирал Баянгийн Пүрэвсүрэнг Гавьяат агрономич цолоор, Сүхбаатар сумын ахмад настан Пэрэнлэйн Цэрэнпилийг Ойн гавьяат ажилтан цолоор шагнуулахаар, эрхэлсэн салбартаа амжилт гаргасан зарим хүмүүсийг төрийн одон медалиар шагнуулахаар уламжиллаа. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 8, Алтан гадас одонгоор 36, Хөдөлмөрийн хүндэт медалиар 52 хүнийг шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид тус тус уламжиллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Аймгийн хэмжээнд 2019 оны 6-р сарын 30-ны байдлаар 90372 га-д үр тариа, үүнээс 88037 га-д улаанбуудай, 3935 га-д тэжээлийн ургамал, 3086 га-д тосны ургамал, 1240 га-д төмс, 857 га-д хүнсний ногоо тариалаад байна.

Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн хурлаар тайлант сард Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2016-2018 оны зардлын тайлан болон Ерөө сумын Бугант тосгоныг сум болгох саналын тухай, Сайхан суманд баг байгуулах тухай тогтоолын төслийг хэлэлцүүлж, цаг үеийн ажлын явц байдалтай холбогдуулан хаврын тариалалтын болон мал төллөлтийн тухай Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын мэдээлэл, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай Хушаат сумын Засаг даргын мэдээллийг танилцууллаа.

БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг Сэлэнгэ аймгийн боловсрол, соёл урлаг, спортын салбарын ажилтан албан хаагчидтай 6-р сарын 4-ны өдөр АДБ-ийн “Сэлэнгийн долгио” чуулгын байранд уулзалт хийлээ. Уулзалтад аймгийн Засаг даргын орлогч Б.Нарантуяа, БСШУСЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Нансалмаа, Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга Т.Ням-Осор, Сайдын ажлын албаны дарга, сайдын зөвлөх Ө.Сумъяабаатар, Боловсролын хүрээлэнгийн захирал П.Лхагвасүрэн нарын албаны хүмүүс болон аймгийн Боловсрол, соёл урлаг, спортын салбарын удирдах ажилтан, багш нарын төлөөлөл оролцсон. Уулзалтын эхэнд салбарын сайд салбарын өнөөгийн байдал, бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, яамны зүгээс ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн давхардлыг арилгах, багш сурагчдын хэн хэнийх нь хэрэгцээг хангасан шинэчилсэн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх гэж байгаа талаараа танилцуулсан бөгөөд энэхүү шинэчилсэн хөтөлбөрийг ирэх хичээлийн жилийн 9 дүгээр сарын 1-ээс мөрдөж эхлэхээр бэлтгэлийг хангаж байна. Энэ ажлыг хэрэгжүүлэхэд сургууль цэцэрлэгийг барьж байгуулахаас урьтаж одоогийн байгаа сургууль, цэцэрлэгийн барилгуудыг нарийвчилсан судалгаанд үндэслэн их засварт оруулж, техник тоног төхөөрөмжөөр хангахыг зорьж байгаа бөгөөд энэ удаагийн орон нутгийн томилолтын зорилго нь салбарын ажиллагсадтай уулзаж, санал хүсэлтийг нь сонсох, тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэж, шинээр хэрэгжих сургалтын хөтөлбөрийн талаар харилцан ярилцаж санал бодлоо солилцоход чиглэгдсэн ба оролцогсдын зүгээс сургуулиудын их засвар, цалин хөлсний нэмэгдэл, урлагийн байгууллагын мэргэжлийн уран бүтээлчдийн дутагдал зэрэг асуудлуудаар саналаа хэлж, сонирхсон асуултадаа хариулт авлаа.

Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, Маргаан хянан шалгах газрын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн Г.Нансалмаа, Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын мэргэжилтэн Б.Чойжилгарав нарын бүрэлдэхүүнтэй Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэг 6-р сарын 13, 14-нд манай аймагт ажиллаж, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн салбар зөвлөлийн ажилтай танилцаж, зарим сум, агентлагт ажиллалаа. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс Төрийн албаны шинэчилсэн найруулга хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах үүднээс аймгийн хэмжээний 400 гаруй төрийн албан хаагчдыг хамруулсан сургалтыг мөн зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаад үнэлэлт өгөх, аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга, агентлагийн дарга нартай 2019 онд байгуулсан гэрээний үүргийн гүйцэтгэлийг газар дээр нь шалгах, Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, хандлагад үнэлэлт өгөх замаар ажил сайжруулах шийдвэр гаргах, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг орон нутгийн иргэдэд тайлагнах, сурталчлах, архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэгийн бэлтгэл ажилд

үнэлгээ, дүгнэлт өгөх зорилгоор 6-р сарын 17-21-ний өдрүүдэд нийт сумдад аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг ажиллалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, АДРА Монгол ОУБ-ын “Органик хөдөө аж ахуйн түншлэл” хамтран “Хамтын баталгаажуулалт-нэмүү өртгийн сүлжээ” зөвлөлдөх уулзалтыг 6-р сарын 12-ны өдөр зохион байгуулж, орон нутгийн анхан шатны 30 хоршоо, Сэлэнгэ таван хайрхан дундын хоршоо, Дархан-Уул аймгийн Ургамал, газар тариалангийн хүрээлэн, Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоо, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны төлөөллүүд оролцлоо. Уулзалтын гол зорилго нь органик хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээ, анхан шатны болон дундын хоршооны хамтын ажиллагаа, нэгдсэн маркетинг, ложистикийг хэрхэн шийдэх талаар талуудын байр суурийг сонсож, оролцогчдын санал авсан. 6-р сарын 13-ны өдөр уг төслөөс Олон Улсад органик хүнсийг баталгаажуулах хэд хэдэн төрлийн арга байдгаас харилцан итгэлцэлд тулгуурласан хамтын баталгаажуулалтын байгууллага байгуулж, “Органик хүнс мөн” гэдгийг хамтаараа баталгаажуулах нь хамгийн бодитой, богино хугацаанд хэрэгжих боломжтой гэж үзэн Органик хүнсний тухай хууль, түүнийг дагалдах журамдаа тусгаж өгсөн бөгөөд, хууль, журмыг хэрэгжүүлэх зорилгоор АДРА Монгол Олон Улсын байгууллагын “Органик хөдөө аж ахуйн түншлэл” төсөл нь органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Монгол Улсад хөгжүүлэх эхлэлийг Сэлэнгэ аймагт тавьж, хамтын баталгаажуулалтын тогтолцоог бий болгон, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, эргээд орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд газар тариалан, сүү, сүүн бүтээгдэхүүн, зөгийн аж ахуй эрхэлдэг Сэлэнгэ аймгийн анхан шатны 30 хоршоо, нэг дундын хоршоог сонгон авч төсөлдөө хамруулж, тэдний органик хөдөө аж ахуй, органик хүнс үйлдвэрлэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хандлагыг өөрчлөх, чадавхжуулах олон төрлийн сургалт явуулж, тоног төхөөрөмж, санхүүгийн дэмжлэг үзүүлэн, иргэд, хоршоодын талбайгаас хөрс, усны дээж авах, шинжлүүлэх зэрэг олон ажлыг зохион байгуулж байна. Үүний үр дүнд төсөлд хамрагдаж буй Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын “Баяжих сүүн булаг”, Шаамар сумын “Органик бал”, Сант сумын “Усан хээр” хоршооны нийт 21 ногоочин өөрсдийн санаачилгаар “Сэлэнгэ органик” нэртэй хамтын баталгаажуулалтын байгууллага байгуулж, органик хүнс үйлдвэрлэлд шилжиж байгаагаа илэрхийлж, тангараг өргөлөө.

Онцгой байдлын газрын ажил үйлчилгээний талаар

Урин дулааны улирал, ард иргэдийн амралт зугаалгын цаг эхэлсэнтэй холбогдуулан гамшиг ослын үед ажиллах бэлэн байдлыг хангуулах ажлыг зохион байгуулж, болзошгүй үер усны аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс анхааруулга сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг орон нутгийн телевизээр хүргэн ажиллаж байна.

2019 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд объектын гал түймрийн дуудлага-7, эрэн хайх аврах ажиллагааны дуудлага-1, усны ослын дуудлага-8, ой, хээрийн түймрийн дуудлага-4 нийт 20 удаагийн дуудлагаар ажиллаж шуурхай арга хэмжээ авч ажиллаж ажиллалаа.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Аймгийн Татварын хэлтсээс Монгол Улсад Атар газар эзэмшсэний 60 жилийн ойг тохиолдуулан Татварын төлөгчдийн өдрүүд арга хэмжээг “Татвар хөгжлийн үндэс” уриан дор Цагааннуур суманд “Гацуур” ХХК, сумын ЕБС-ийн 12 жилийн сургуультай хамтран зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд шилдэг тэргүүний татвар төлөгчдийг шагнаж урамшуулснаас гадна тэдний үйл ажиллагааг орон нутгийн телевизээр сурталчиллаа. Татвар төлөгчийн өдрүүдээр нийт сум, тосгодын 8643

татвар төлөгчдөд ажлын байрны сургалт, 4821 татвар төлөгчдөд танхимын сургалтыг хийж, татвар төлөгчдийн дунд уралдаан тэмцээн зохион байгууллаа.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		37.498.435.0	34.164.263.3	91.1
1.1	Орон нутгийн төсвийн орлого	10.876.376.9	8.457.736.4	77.8
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	8.945.076.5	6.377.974.0	71.3
	Сумдын төсвийн орлого	1.931.300.4	2.079.762.4	107.7
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	2.748.428.7	2.748.428.7	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	20.825.912.9	20.825.912.5	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	2.915.290.6	1.999.759.7	68.6
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	600.0	600.0	100.0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	131.825.9	131.825.9	100.0
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого	174.783.9	101.881.9	58.3
1.8	Сум хөгжүүлэх сангийн орлого	1.210.366.2	1.038.221.6	85.8
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		40.695.138.4	29.789.271.0	73.2
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	40.695.138.4	29.789.271.0	73.2
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	33.117.314.4	25.391.044.6	76.7
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	1.142.960.5	30.978.7	2.7
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	7.577.824.0	4.398.226.4	58.0
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	600.000.0	134.319.3	22.4
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	349.000.0		
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	1.589.825.6	668.178.0	42.0
	Халамжийн сан	157.057.5	82.200.0	52.3
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	4.664.140.9	3.338.501.4	71.6
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	217.800.0	175.027.7	80.4
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	24.020.746.4	19.936.102.5	83.0
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	545.147.0	509.086.4	93.4
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		27.856.652.4	27.159.473.7	97.5
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	6.971.817.0	6.274.635.3	90.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1.272.142.6	1.081.421.9	85.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	58.892.5	58.895.5	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд			
	Хөрөнгө оруулалтын зардалд	1.054.960.5	1.022.526.4	96.92
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1.589.825.6	892.998.1	56.2
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	1.243.674.6	668.178.0	53.7
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	163.500.0	163.500.0	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	20.487.274.1	20.487.274.1	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	338.668.8	338.668.8	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	20.825.912.9	20.825.912.9	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	10.345.421.5	10.345.421.5	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	7.220.411.4	7.220.411.4	100.0

	- Соёлын байгууллага			
	- Биеийн тамир спортын байгууллага			
	- Эрүүл мэндийн байгууллага	2.869.248.7	2.869.248.7	100.0
	- Газрын кадастрын байгууллага	193.970.3	193.970.3	100.0
	- Хүүхдийн байгууллага	196.861.0	196.861.0	100.0
4. Тусгай сангуудын зарлага				
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	853.339.2	74.470.5	8.7

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2018 05- сар	2019 05- сар	<u>2019- 05</u> <u>2018-05</u> Х/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 100	1 100	100.0
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 200	109.1
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 400	100.0
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6 500	8 500	130.8
	Үхрийн мах /кг/	8 000	9 800	122.5
	Адууны мах /кг/	6 000	8 000	133.3
	Ямааны мах /кг/	5500	8 000	145.5
	Дотор мах, цувдай /цусгүй/	3500	4 000	114.3
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	800	1 000	125.0
	Сүү / савласан, л/	2 600	2 700	103.8
	Тараг /задгай, л/	1 200	1 300	108.3
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	12 000	15 000	125.0
	Айраг /л/	3 500	3 500	100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	1 500	2 000	133.3
	Шар тос /кг/	13 000	13 000	86.7
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 200	1 000	83.3
	Лууван /кг/	1200	1 200	100.0
	Манжин /кг/	1500	1200	80.0
	Байцаа /кг/	1500	1500	100.0
	Сонгино /кг/	1500	1500	100.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 300	100.0
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 530	1 770	115.7
	Бензин А - 92	1 735	1 940	111.8
	Дизелийн түлш	2 020	2 400	118.8

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Улсын бүртгэлийн хэлтсээс энэ сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 245, лавлагаа 6 бичиж, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 165, лавлагаа 39 олгож үйлчиллээ.

Иргэний бүртгэлийн үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд үзүүлж ажиллалаа.

Үүнд:

- Төрсний бүртгэл – 193 /эрэгтэй-106, эмэгтэй-87/
- Гэрлэлтийн бүртгэл – 48
- Гэрлэлт цуцалсны бүртгэл – 11
- Эцэг тогтоолт – 46
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 9
- Нас баралт –52
- Нийт олгосон иргэний үнэмлэх – 436
- Шинээр олгосон иргэний үнэмлэх – 193
- Дахин олгосон иргэний үнэмлэх – 78
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 165
- Гадаад паспорт олголт – 119
- ОХУ-ын хавсралт - 2999
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн –184
- Хот доторх шилжилт хөдөлгөөн – 306 тус тус бүртгэгдсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр

2018-2019 оны хичээлийн жилд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдээс авах улсын шалгалтыг зохион байгуулсан. Мөн Их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах ерөнхий шалгалтыг 6 дугаар сарын 17-ноос 20-ны өдрүүдэд 10 хичээлээр зохион байгуулж, “Шилэн технологи”-ийг ашиглан шууд засаж, оноог танилцуулж ажилласан.

Энэ хичээлийн жилд аймгийн хэмжээнд 33 сургуулиас суурь болон бүрэн дунд боловсролын гэрчилгээний захиалга авч нэгтгэн яаманд хүргүүлсэн бөгөөд суурь боловсролын гэрчилгээ 1398, бүрэн дунд боловсролын гэрчилгээ 390 нийт 1788 гэрчилгээ захиалж, 9834000 төгрөгийг тушаасан.

Тус аймагт энэ хичээлийн жилд 1395 суралцагч суурь боловсрол 1358 суралцагч өдрөөр суралцагч, 37 дүйцсэн хөтөлбөр, 387 суралцагч бүрэн дунд боловсрол 360 суралцагч өдрөөр суралцагч, 27 дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж нийт 1782 төгсөгчдөд суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ үнэмлэхийг олгосон.

Мандал сумын “Нархан” цэцэрлэгийн эрхлэгч Г.Гэрэлмаа, Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн бага ангийн сургалтын менежер Э.Алтантуяа, Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн монгол хэлбичиг, уран зохиолын багш Л.Атарцэцэг, Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн химийн багш С.Баярсайхан нарын 4 багшид “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг олгуулахаар багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн төвд хүргүүлсэн.

2019 оны 6-р сарын 03-аас 7-р сарын 5-ыг хүртэлх хугацаанд Сүхбаатар сумын 2, 3 дугаар цэцэрлэг, Мандал сумын Нархан цэцэрлэгүүдэд зуны цэцэрлэгийг тус бүр 100, нийт 300 хүүхдийг хамруулсан. Цэцэрлэгт хамрагдаж чадаагүй малчид, ногоочид, тариаланчдын хүүхдүүдэд үйлчилгээний боломжит нөөц бололцоог бий болгон зарим цэцэрлэгүүдэд хувилбарт сургалт /нүүдлийн, ээлжийн, явуулын багшийн сургалт/, 24 цагийн бүлэг ажиллуулах зэрэг арга хэмжээг авч, үйл ажиллагааг зохион байгуулж байна. 2018-2019 оны хичээлийн жилд 14 цэцэрлэг 6 дугаар сарын 02-оос эхлэн 8 дугаар сарын 20-ны хооронд тус бүр 1 сарын хугацаатай нүүдлийн болон ээлжийн бүлэг ажиллуулж 606 хүүхдийг тусгай хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хамруулан, хамран сургалтаа нэмэгдүүлж, СӨБ-ын үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор 6-р сарын 12-16-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Азийн ардын урлагийн их наадам" гадаадын 12 улсын 200 гаруй ардын авъяастан, үндэсний 21 аймаг, 9 дүүргийн 2000 гаруй ардын авъяастан, уран бүтээлчдийн дунд ардын дуу, ардын хөгжим, ардын бүжиг, зан үйлийн чуулга, язгуур урлагийн чуулга гэсэн 5 төрлөөр зохион байгуулагдаж, ардын дууны гоцлол төрөлд ардын дуу бүжгийн "Сэлэнгийн долгио чуулга"-ын дуучин Б.Цолмо нийт 145 дуучнаас 3-р байр, ардын хөгжмийн гоцлол төрөлд З.Одонтунгалаг 80 хөгжимчнөөс 3-р байр, ардын хөгжмийн хамтлаг төрөлд Таванхан морин хуурын хамтлаг 16 хамтлагаас 2-р байр, Язгуур урлагийн төрөлд 46 хамтлагаас Сайхан сумын Нарны охид хамтлаг 4-р байр, Зан үйлийн чуулгын төрөлд 29 хамтлагаас Жавхлант сумын Эгшиглэн хамтлаг 4-р байранд тус тус шалгарч, Дэлхийн ардын урлагийн наадамд оролцох эрхийг "Таванхан" хамтлаг гардан авсан.

Монголын хүүхдийн спортын VI их наадмын дугуйн спортын төрөлд оролцох тамирчдыг сонгон шалгаруулах зорилгоор "Барселон Олимпын Зөвлөл"-ийн дарга дугуйн спортын мастер Д.Эрдэнэбатын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах дугуйн тэмцээнийг 16 хүртэлх нас, 17-18 насны ангиллаар зохион байгуулж, нийт 90 гаруй тамирчид оролцлоо.

Монгол Улсын шигшээ багийн тамирчин, волейболын спортын ууган мастер Ш. Жамъяаншарав агсаны нэрэмжит насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах 17 дахь удаагийн тэмцээнийг зохион байгуулж, эмэгтэй 7 баг эрэгтэй 12 багуудын нийт 212 тамирчин оролцоноос эрэгтэйчүүдээс Д.Билэгт ахлагчтай 6-р сургуулийн баг тэргүүлж, Болдбаяр ахлагчтай Мандал сумын баг, Энхманлай ахлагчтай Орхон сумын багууд эхний байранд, Эмэгтэйчүүдээс А.Батдулам ахлагчтай спорт сургуулийн баг тэргүүлж, Б.Сарангэрэл ахлагчтай Сэлэнгэ баг, С.Энхжаргал ахлагчтай Хэрх багууд эхний 3 байранд шалгарсан.

2.Эрүүл мэндийн чиглэлээр

Азийн Хөгжлийн банкны "Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр-5" төслийн хүрээнд 2015-2019 онд нийт 11 тэрбум 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн нэгдсэн эмнэлэгт цусны банк, төвлөрсөн ариутгал, нян судлалын лаборатори, эмнэлгийн гаралтай хог хаягдлын менежментийг сайжруулах төслүүд, Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн цусны салбар банкны үйл ажиллагааг сайжруулах төслүүд хэрэгжсэн бөгөөд энэ 6-р сарын 12-ны өдөр төслийн хаалтын ажиллагааг зохион байгуулсан.

"Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн 2-12 насны 23094 хүүхдийг 2019-2023 онд үзлэгт хамруулах зорилтыг тавьж, шүдний хувийн эмнэлгүүдийн дунд сонгон шалгаруулалтыг хийж, Сүхбаатар сумын "Тод Смайл", "Тэгш Дент", Мандал сумын "Элгэмсэг Хараа" зэрэг 3 шүдний эмнэлэг шалгаран гэрээ байгуулж, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээг хийж эхэлсэн бөгөөд, эхний хагас жилийн байдлаар нийт 299 хүүхдийг үзлэгт хамруулж, 6 төрлийн эмчилгээг хийж, эрүүлжүүлэлт 86 хувьтай байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн хүүхдийн зүрх судасны эмч нартай хамтран "Хүүхдийн зүрх судасны эмгэгийн үеийн оношлогоо эмчилгээ" сургалтыг 6 сард зохион байгуулж, 60 гаруй эмч, мэргэжилтнийг хамрууллаа.

"Сүрьеэгүй Сэлэнгэ" аймгийн хөтөлбөрийн хүрээнд 5-р сарын 23-наас 6-р сарын 14-ний хооронд Аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэгийн "Сүрьеэгийн тархвар судлал, цээжний хөндийн эмгэг илрүүлэх эрт илрүүлэг"-ийн хамтарсан баг Баянгол, Хүдэр, Ерөө, Орхон, Сайхан сум, Хэрх, Түнхэл, Бугант, Рашаант тосгонд ажиллаж тухайн орон нутгийн сүүлийн 5 жилд сүрьеэгээр өвчилсөн тохиолдолд хавьтлын судалгаа хийж, хамрагдвал зохих иргэдийн 90 хувийг үзлэгт хамрууллаа.

"Хүн бүрт сайн чанар бий, байгууллага бүрт давуу тал бий" уриан дор аймгийн "Эмч солилцоо" арга хэмжээг зохион байгуулж 7 хоногийн хугацаанд зохион

байгууллаа. Арга хэмжээнд аймгийн 2 Нэгдсэн эмнэлэг, 1 сум дундын эмнэлэг, сум, тосгодын эрүүл мэндийн төвийн дарга нар хамрагдлаа.

3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

Аймгийн хэмжээнд 2019 оны 5-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 753 байсан бол 309 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 306 ажлын байранд 258 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 165 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 639 болсон.

Нийгмийн халамжийн сангаас 6 сарын байдлаар 37,995 иргэнд 7,657,848.3 мянган төгрөгийг олгоод байна.

"Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд: "Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар"-аас эрх авсан "Монголын хүний нөөцийн менежментийн холбоо ТББ"-тай хамтран Түшиг, Цагааннуур, Хүдэр сум Түнхэл тосгоны 90 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг "Бизнесээ эхлүүлэе, хөгжүүлэе, төсөл бичих" сургалтанд хамруулж, ХЭДС-аас 1350.0 мянган төгрөгийг, "Зүүнхараа политехник коллеж"-тэй хамтран Сүхбаатар, Мандал сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны хүсэлтээр 18 иргэнийг Оёдол-эсгүүрийн сургалтанд хамруулж, ХЭДС-аас 4212.0 мянган төгрөгийг, Дархан-Уул аймгийн "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв"-тэй хамтран Мандал, Сайхан, Шаамар, Зүүнбүрэн сум Хэрх тосгодын 150 иргэнийг бизнес төсөл боловсруулах 3 хоногийн сургалтанд хамруулж, ХЭДС-аас 2250.0 мянган төгрөгийг зарцууллаа.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор "Вест Метод" ХХК-ий дэргэдэх "Бест иннобаци бизнес хөгжлийг дэмжих төв"-тэй хамтран Сүхбаатар суманд 3 өдрийн сургалтыг зохион байгуулж 18 бүлгийн 36 иргэнийг шалгаруулж, ХЭДСангаас 20000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож 36 ажлын байрыг шинээр бий болсон. Мөн Сүхбаатар, Мандал сумын 110 ажилгүй залуучууд болон оюутан суралцагчдад "Бизнесээ эхэлэе, хөгжүүлэе, төсөл бичих" чиглэлээр аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж 1650.0 мянган төгрөгийг зарцуулсан

Сумдаас сумдад хийгдэх ажлын саналыг авч бүтээн байгуулалтын чанартай ажлыг сонгож гэрээ байгуулан хэрэгжүүлж нийт 10 сум 3 тосгоны байгалийн гамшгаас үүдэлтэй хор уршиг арилгах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн бүтээн байгуулалт, тохижилт, байгаль орчинг хамгаалах зэрэг ажилд 236 иргэнийг түр ажлын байраар хангаж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 33135.2 мянган төгрөгийг цалин болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардалд зарцуулсан. Сумдаас зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээний судалгаа авч Мандал сум Түнхэл, Бугант, Дулаанхаан тосгоны 36 иргэнийг хамруулж урамшуулалд 26400.0 мянган төгрөгийг ХЭДСангаас олгосон. Өрхийг малжуулах арга хэмжээний хүрээнд Түшиг, Ерөө, Хүдэр, Баруунбүрэн, Орхонтуул, Сант, Баянгол, Жавхлант сум Бугант, Хэрх, Түнхэл, Номгон тосгодын шаардлага хангасан 52 өрхийг тухайн сумын "Амьжиргааг дэмжих зөвлөл"-өөр сонгон мал худалдан авч өгөх ажлыг зохион байгуулан 452 толгой мал /тугалтай үхэр болон тугалах гунж/-аар малжуулж ХЭДСангаас 242600.0 мянган төгрөгийг зарцуулсан. Үүний үр дүнд 104 ажлын байрыг шинээр бий болсон.

"Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт Цагааннуур, Ерөө, Мандал, Баянгол сум Хэрх, Номгон тосгоны худалдаа үйлчилгээ, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй, оёдол эсгүүр, ахуй үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 9 ахмад настны хүсэлтийг хүлээн авч төсөл сонгон шалгаруулах комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэж ХЭДСангаас 25000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож 9 ажлын байрыг шинээр бий болгосон. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээний хүрээнд 17 сум 6 тосгоны аж ахуй нэгж байгууллагуудын хүсэлтээр 9 ахмад настнаар зөвлөгөө мэдээллийг Хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, хууль эрх зүй гэх мэт чиглэлээр үйлчилгээг үзүүлж ХЭДСангаас тэдгээр ахмадуудад 3150.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон.

Цагааннуур суманд үйл ажиллагаа явуулдаг Нарийншүрэн ХХКомпани нь хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг байнгын ажлын байраар хангаж, аж ахуй нэгжид Хөдөлмөр эхрлэлтийг дэмжих сангаас 5760.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон. Цагааннуур сумын Ноён Уулын хишиг ХХК 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулахаар гэрээ байгуулсан.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Тайлант сард Хүүхдийн тусламжийн 108 утсанд нийт 11 дуудлага ирж хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлсэн. Дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрлөөр ангилбал бие махбодын хүчирхийлэл 1, үл хайхрах хүчирхийлэл 2, сэтгэл санааны хүчирхийлэл 6, бэлгийн хүчирхийлэл 2 байна. Бэлгийн хүчирхийллийн хохирогч 8 хүүхдийн мэдээллийг эрсдлийн программд оруулсан.

Гэр бүлийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан 270 өрхөөс Баруунбүрэн сумын 15 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж, сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө үйлчилгээ үзүүллээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа Улаанбаатар хотын хорих 407 дугаар ангид хүмүүжиж байгаа ээжүүдийг хүүхдүүдтэй нь уулзуулах “Эх үрсийн нандин хайр” өдөрлөгт Ерөө сумын иргэн 3, хүү Э болон түүний төрсөн дүү нарыг уулзуулсан.

“Гэр бүлийн зөвлөгөө өгөх танхим”-аар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1 зан төлөвийн өөрчлөлттэй 1 нийт 2 хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн. Шүүхийн шүүгчийн захирамжийн дагуу 1 хүүхдийн асран хамгаалагч тогтоох шинжээчийн дүгнэлт гаргасан.

“Хүүхэд хамгаалалд эцэг эхийн оролцоо”, “Гэр бүлийн хүчирхийллээс хүүхдийг хамгаалах нь”, “Хүүхэд хамгаалагчийн ажиллах журам”, Дэлгэцийн донтолт”, “Архи, тамхины хор уршиг”, “Стресээ даван туулах нь” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгууллаа. Мөн Монгол Улсын Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 3 тоот тогтоолоор батлагдсан “Хүүхэд хамгааллын жишиг баримт бичиг”, “Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж”-ийн хэрэгжилтийг хангаж, төрийн байгууллагын хүний нөөц, бичиг хэргийн ажилтан, ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт чиглэл өгч, 40 гаруй төрийн албан хаагчид хамрагдсан.

Байгууллагын эцэг эхийн зөвлөлийг 64 байгууллага, 20 сургууль, 18 цэцэрлэг байгуулж, байгууллага бүр “Хүүхэд хамгааллын жишиг баримт бичиг”-ийг албан хаагчиддаа танилцуулан баталгаажуулж, жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоор орж хөгжлийн бэрхшээлтэйг тодорхойлсон 17 хүүхдийг Хүүхэд хөгжлийн төв Гүннуур зусланд үнэ төлбөргүй амраалаа.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

2019 оны 6 сарын байдлаар 15,60 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 6-р сарын 24-ний байдлаар өссөн дүнгээр 16,69 тэр бум төгрөгийн орлого төвлөрүүлж, 106.96 хувийн биелэлттэй байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16740 тэтгэвэр авагчдад 28908.44 сая төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 3264 хүнд 1309.68 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 246 хүнд 494.65 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 218 хүнд 325.90 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжийн тус тус олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс 6-р сард 4 удаа хуралдаж, 320 хүнээс, 18 хүнийг цуцалж, 45 хүн шинээр тогтоолгосон, 257 хүн актаа сунгуулсан.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг 645 иргэд, даатгуулагчдад гарган үйлчилж, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг Ерөө сумын “Болд төмөр Ерөө гол” ХХК-ий 320 ажилчдад, Хүдэр Хушаат сумын аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, бичил уурхай эрхлэгчдэд нийт 168 иргэд, Бугант тосгоны аж ахуйн нэгж байгууллага, мал бүхий иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 52 иргэнд тус тус зохион байгуулсан.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Хаврын тариалалтын мэдээг сумдаас авч нэгтгэн, долоо хоног бүрийн 2,5 дахь өдрүүдэд ХХААХҮЯаманд хүргүүлэн ажиллаж байна.

Азийн Хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар ХХААХҮЯ-ны хамтарсан “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амжиргааг сайжруулах 9192-МОН” төсөл Ерөө суманд хэрэгжих болсон бөгөөд нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Мөн ХҮнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хамтран зохион байгуулсан “Мал аж ахуйн салбар дахь жендэрийн дүн шинжилгээ” сэдэвт 3 өдрийн сургалтанд холбогдох мэргэжилтнүүд хамрагдлаа.

Энэ хавар аймгийн хэмжээнд 726820 эх мал төллөхөөс 6 дугаар сарын 22-ны байдлаар 539974 мянган толгой эх мал төллөснөөс ингэ 124, гүү 15333, үнээ 44738, хонь 278496, ямаа 201283 төллөж, мал төллөлт 74%, төлийн бойжилт 99.9 хувь буюу 539652 төл бойжиж байна. Мал төллөлт Жавхлант, Орхонтуул сумдад хамгийн өндөр буюу 94-98 хувьтай байгаа бол Мандал, Баруунбүрэн, Хүдэр сумдад 55-68 хувьтай байна.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

Сүхбаатар сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт шинээр газар эзэмших 16 иргэн, 1 төрийн байгууллага, эрх баталгаажуулах 4 иргэн, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх 12 иргэн, 1 аж ахуйн нэгж, эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлт гарсан 2 иргэн, газар эзэмших эрхийн Э дугаар авах хүсэлт гаргасан 40 өргөдөл хүсэлтийг хүлээн авч, аймгийн Засаг даргын 4 удаагийн захирамжаар нийт 16 иргэнд шинээр газар эзэмшүүлж, 1 иргэний газар эзэмших эрхийг баталгаажуулж, 1 иргэний эзэмшил газрын зориулалтыг өөрчлөн хуулийн хугацаанд өргөдлийг шийдвэрлэв.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар 28 иргэн, 3 аж ахуйн нэгж, 1 төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээнд Э дугаар авах хүсэлтийг дундын мэдээллийн сангаар дамжуулан Улсын бүртгэлийн хэлтэст илгээж, 19 иргэн, 1 аж ахуйн нэгж, 1 төрийн байгууллагад газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулан газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэж баталгаажууллаа.

Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 47 кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сан Лэнд менежер програмд бүртгэж баталгаажуулж, Сүхбаатар сумын 26 иргэнд шинэчилсэн хаягаар кадастрын зургийг үнэт цаасан дээр хэвлэн иргэдэд үйлчилсэн байна.

“Газрын тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах, газрын зөрчил арилгах үйл ажиллагааг эрчимжүүлэх, нийтийн эзэмшлийн зам талбайн газар ашиглалтыг сайжруулах зорилгоор байгуулагдсан “Газрын зөрчил арилгах ажлын хэсэг”-ээс Ерөө сумын Тавин багийн нутаг дэвсгэрт газар сунгасан болон зөвшөөрөлгүй газар ашигласан 6 иргэнд газар чөлөөлөх хугацаат мэдэгдлийг хүргүүлээд байна.

Долоо. Байгаль орчны чиглэлээр

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын санаачлагаар Монгол орон даяар хэрэгжиж буй “Ногоон паспорт” аяны хүрээнд “Хандлагаа өөрчилье” уриатай ногоон паспорт эзэмшигч ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулсан “Байгаль хамгаалах уламжлал” гар зургийн уралдаан, “Эко-клуб”-ээс “Нэг удаагийн хальсан уутнаас татгалзъя” видео уралдаануудад шалгарсан, идэвх санаачлага гаргаж амжилттай оролцсон сурагчдыг хамруулан аймгийн Боловсрол, соёл, урлагын газартай хамтран “Ногоон паспорт-хэлэлцүүлэг”-ийг Сүхбаатар суманд зохион байгуулсан. Эко клубын сурагчдын дунд зохион байгуулсан “Нэг удаагийн нийлэг хальсан уутнаас татгалзъя” видео бичлэгийн уралдаанд тэргүүн байрт шалгарсан Сүхбаатар сумын ерөнхий боловсролын III сургуулийн “Эко клуб”-ын хамт олонд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Өргөмжлөл”-ийг гардуулж, мөнгөн шагналаар урамшуулсан. “Байгаль хамгаалах уламжлал” гар зургийн уралдаанд оролцсон 33 сурагч, “Нэг удаагийн хальсан уутнаас татгалзъя” видео уралдаанд 4 эко-клубын сурагчдад Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Талархлын бичиг”-ийг гардууллаа.

Аймгийн Засаг даргын “Хяналтын цэг ажиллуулах тухай” 2019 оны А/86 тоот захирамжийн дагуу байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгаль хамгаалах зорилгоор хяналтын пост 3-р сарын 25-ны өдрөөс 6-р сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд Ерөө сумын нутаг Могойн даваа, Ялбаг, Хүдэр сумын нутаг Нүхэн гүүрэнд ажиллуулсан.

Найм.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

УИХ-ын гишүүн, хүний эрхийн дэд хорооны дарга Н.Оюундарийн санаачилгаар Алтанбөулаг сумын 290 жилийн ойг угтан “Алтанбулага-290 өнгөрсөн, одоо, ирээдүй” Олон Улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгууллаа.

Ойг угтан сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийг цэвэрлэж, бүх нийтийн их цэвэрлэгээг хийж 400 орчим иргэн оролцлоо. Орон нутгийн сангийн хөрөнгөөр “Суварга” багт хүүхдийн тоглоомын талбай хийсэн бөгөөд сумын төр, төсвийн байгууллагуудын орчны тохижилтын ажлууд хийдлээ. Тухайлбал: Сумын цэцэрлэг хашааныхаа ногоон байгууламжийг нэмэгдүүлж 4 ширхэг цэцгийн мандлыг хийж, хашаагаа шинэчилснээс гадна туршилтын 2 хүлэмжийг байршуулсан. Сумын сургууль 32 м2 талбайд 3 төрлийн цэцэг тарьж, 14 м2 талбайд цэцгийн мандал хийж 8 төрлийн 102 цэцгийн үрсэлгээг сулгалаа.

Мөн нийтийг хамарсан ажлын хүрээнд хөшөөг сэргээн засварлах, талбайн суудлыг засар, үерийн далангийн хогийн цэвэрлэгээ, гудамж талбайн гэрлийн шон, тоглоомын талбайг засварлалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Спортын ордон”-ы шав тавих ёслолын бажиллагааг зохион байгуулж, “Энх Бизнес Өгөөмж” ХХК гүйцэтгэж байна.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн улсын дундаж тогтоох, хүүхэд бүрийн хөгжлийн бариа үнэлэх үнэлгээг сумын 0-3 насны 39, 3-6 насны 115 хүүхэд, нийт 154 хүүхдийг хамруулсан. “Дамбо” цэцэрлэг зуны хувилбар сургалтыг 6-р сарын 2-оос 7-р сарын 1 хүртэл 2 бүлэгт 82 хүүхдийг хамруулсан.

Сум хөгжүүлэх сангийн төсөл шалгаруулах ажлыг 6-р сарын 13-нд зохион байгуулж, 14 иргэний төсөлд сонгон шалгаруулалт явуулж, нийт 75,0 сая төгрөгийн 5 төслийг дэмжлээ.

Сумын хэмжээнд малын түүвэр судалгааг 6-р сарын 3-аас 10-ны хооронд зохион байгуулж, 58 өрхийг судалгаанд хамрууллаа. Малд үзлэг ангилалт хийж ажлыг мөн сарын 5-15ны өдрүүдэд зохион байгуулж, баяд үүлдрийн цэвэр эрлийз 1700 хонь, 800 гаруй ямаа, бог малын хээлтүүлэгчийг ялган 2 өрхөд 250 орчим хуц, ухныг бүртгэлд хамрууллаа.

Мал төллөлт, төл бойжилтын мэдээгээр сумын хэмжээнд 23872 мал төллөхөөс 22062 мал төллөж, төл бойжилт 92 хувьтай байна. Том малын зүй бусын хорогдол 328, үүнээс 168 хээлтэгч мал байна.

Баруунбүрэн сум:

Сумын дүнгээр 2018 оны жилийн эцэст нийт 72567 толгой хээлтэгч тоологдсоноос 60053 толгой хээлтэгч төллөхөөс 40707 толгой нь төллөж 67,7%-тай байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар “Цөлжсөн элсний нүүлтэд өртсөн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах”, “хуш,сибир жодооны” тарьц суулгацаар ойжуулалт хийх ажлын хүрээнд “Ойн Ирээдүй” мод үржүүлгийн газраас шинэсний 9500, жодооны 30, хушны 150 ширхэг тарьцыг авч, ойжуулалтын ажлыг хийсэн.

Сумын эрүүл мэндийн төвд тайлант сард амбулаторийн үзлэг 123 хийгдэж, 200 иргэн шинжилгээнд хамрагдаж, эмнэлэгт хэвтсэн 25 иргэнд үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Жирэмсний хяналтанд байгаа 26, шинээр жирэмсний хяналтанд орсон 7 иргэн байгаа ба шаардлагатай шинжилгээгээ өгсөн эерэг гарсан тохиолдол илрээгүй байна. “Хэнд ч, хаана ч” уриан дор цусны донорын дэлхийн өдрийг тохиолдуулан сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэн, донорын үйлсийг сурталчилан олон нийтийн оролцоог алдаршуулах, талархал илэрхийлэх зорилготой аяныг зохион байгуулж, нийт 3 хүнийг донорын бүртгэлд элсүүлэн шинээр бүртгэсэн. “Цусны донор хүн та цусаа бэлэглэж амьдрал хайрлая” сэдвээр 6-р сарын 14-ны өдөр сургалт хийж, 30 иргэнд сурталчилгааны материал тараасан. Арга хэмжээнд оролцогчдын дунд АХА тэмцээн зохион байгуулж, хөгжилтэй асуулт, IQ-н болон донорын тухай мэдээлэлтэй холбоотой асуулт асууж, сэтгэн бодох чадвар, мэдлэг мэдээллийг шалгах, дүгнэх маягаар тэмцээнийг зохион явууллаа.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн шүдний эмч 6-р сарын 15, 16-нд хүүхдийн шүдийг оношилж, эмчилж, шүд угаах аргачлал, сургалт хийж 50 иргэнд хамрагдлаа.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 130 хүүхдийн гимнастикийн үзүүлэх сургууль, “Эрийн гурван наадам”-ыг насны ангилалаар зохион байгуулсан. Мөн “Хүүхэд бидэнд авъяас бий” цэцэрлэгийн нийт 170-аад хүүхэд оролцож, сумын ард иргэд болон эцэг эхчүүдэд танилцуулан тоглолоо.

Атар газар эзэмшсний 60-н жилийн ойд зориулан агрономич, аймгийн хурц арслан Л.Намжилдорж агсны нэрэмжит Баруунбүсийн шагайн харваан тэмцээнд 7 багийн нийт 80 гаруй харваачид ирж цэц мэргэнээ сорьлоо.

Мандал суманд болсон Мини волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд Ө.Энхтүвшин багштай өсвөрийн баг тамирчид амжилттай оролцож Э.Гансоронз, О.Мөнхтулга нар улсын аварга шалгаруулах тэмцээний эрх авсан. Мөн суманд болсон “Баруун бүсийн тэмцээн”-д гар бөмбөгийн дугуйлангийн хүүхдүүд оролцож, хүрэл медалийн эзэд боллоо.

Монгол Улсын Засгийн газраас баталсан Биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого шийдвэр, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, иргэдийн дунд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, нийтийн биеийн тамираар хичээллүүлж нийтийн эрүүл мэндийг бэхжүүлэх, хөдөлгөөний дутагдалаас сэргийлэх, хүүхэд залуучуудыг чийрэгжүүлэх, дугуйн спортыг олон нийтэд сурталчилан таниулах зорилгоох “Дугуйтай өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулсан.

Тус сум нь 2019 онд 40 шинэ ажлын байр бий болгохоос 24 шинэ ажлын байранд зуучилж, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малжуулах арга хэмжээнд хамрагдаж байгаа 4 өрхтэй гэрээ байгуулж, хөдөлмөрт бэлтгэх сургалтыг зорилтод бүлгийн болон хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг 31 иргэнд 3 өдрийн сургалт зохион байгууллаа.

Мандал сум:

2019 оны хаврын тариалалтын үрэнд нөөцөлсөн 17 аж ахуйн нэгж, байгууллагын 694,2 тонн үр, дутагдалтай байсан 362 тонн үрийг Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Улсын үрийн нөөцийн салбар, аж ахуйн нэгж байгууллагуудаас татан авч, тариалалтыг 18 хоногийн хугацаанд дуусгаад байна. мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголт явууллаа.

Мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх арга хэмжээний 6 төрлийн тарилгад давхардсан тоогоор 74075 толгой мал, амьтныг хамрууллаа.

Энэ сард талбай тусгаарлалт хийлгэх хүсэлт гаргасан 2 нөхөрлөл, 9 аж ахуйн нэгж байгууллагын 2 нөхөрлөл, 7 аж ахуйн нэгж, байгууллагын 118 га талбай тусгаарлалт хийж, материалыг боловсруулж

Аймаг, сумын Засаг даргын захирамжийн дагуу сумын хэмжээнд 2019 оны “Тээврийн хэрэгслийн /автомашин, өөрөө явагч механизм, мотоцикл, чиргүүл/-ийн техникийн хяналтын улсын үзлэгийг зохион байгууллаа.

Хүүхэд залуучуудын цагийг зөв боловсон өнгөрөөх орчныг бүрдүүлэх зорилгоор Ширхэнцэг цэцэрлэгт хүрээлэнд элсны гар бөмбөгийн талбайг байгуулсан.

Өнгөрсөн 5, 6 дугаар сард сумын төвийн зориулалтын бус 7 хэсгийн хог цэг, нийтийн эзэмшлийн 95 га талбайн хог цэвэрлэгээг хийж, Улаанбаатар–Дархан чиглэлийн /А0401/ авто замын 130 км-ээс Мандал сум хүртэлх хуримтлуулах 30 км авто зам, Минжийн хангайн 7-р багт Цагдаагийн албан хаагчдын 5 давхар 30 айлын орон сууцны барилга, сумын шинэ суурьшлийн бүсийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 8 км орчим 6 киловольтын кабель шугам, 0.4 киловольтын агаарын шугам, 100-400 киловаттын хүчин чадалтай 16 ширхэг трансформатор, 1 ширхэг хуваарилах байгууламж барих ажлуудыг эхлүүлсэн.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл тайлант сард 2 удаа хуралдаж хорих ангиас суллагдсан, өөрийн гэсэн гэр оронгүй 1 иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж, 1 өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж, байнгын асаргаа шаардлагатай ахмад шинээр 2, сунгалт 7, хөгжлийн бэрхшээлтэй иргэн шинээр 1, сунгалт 2, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 1 иргэнд олгохоор шийдвэрлэж, “Бум Хараа” ХХК-ийн хаш чулуун эмчилгээнд ахмад настан 100 иргэн, “Алтан од” сувиллын эмчилгээнд 50 иргэнийг 7 хоног хамруулахаар шийдвэрлэлээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, идэвхжүүлэх чиглэлээр “Хамтдаа хөгжье” 6 төрөлт спортын тэмцээнийг зохион байгуулж, 30 гаруй иргэнийг хамрагдсан.

Баянгол сум

Монгол Улсын газар тариалан бие даасан салбар хөгжиж, Атар газар эзэмшсэний түүхт 60 жилийн ойг тохиолдуулан аймгийн хэмжээнд зохион байгуулж буй “Атар-60” туг, хүндэтгэлийн дэвтрийн аялал энэ сард манай суманд үргэлжиллээ. 2019 оны тариалалтын эцсийн мэдээгээр улаанбуудай 5765 га-д, овъёос 70 га-д, гурвалжин будаа 351 га-д, ногоон тэжээл 362 га-д, рапс 2104 га-д, төмс 102 га-д, хүнсний ногоо 92,31 га-д тариалаад байна.

Малын хагас жилийн малын түүвэр судалгаа зохион байгуулж, түүврээр сонгогдсон 127 өрхийн малыг тооллогод хамруулсан. Мөн Бог малд үзлэг ангилалт хийж ажлыг зохион байгуулж, 3000 толгой хонь, 1000 толгой ямаа, нийт 4000 бог малд төлөв байдлын үнэлгээ хийлээ.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр “Хүүхэд бүхэн жаргалтай байг” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, соёлын төвийн дэргэдэх дуу, бүжгийн дугуйлангийн суралцагчид “Бид эх орны ирээдүй” тайлан тоглолтоо тохилуулж, “Миний хобби” уран хайчилбар, уран зургийн уралдаан, “Орон нутгаа хэн сайн мэдэх вэ?” сэдэвт А.Х.А тэмцээнийг зохион байгууллаа.

Энэ сард Узбекистаны нийслэл Ташкент хотноо болсон Ази тивийн аварга шалгаруулах даамын тэмцээнд сумын ЕБС-ийн багш Б.Лхагвасүрэн 76 ангийн сурагч Н.Орхонцэцэг, 16 ангийн сурагч Л.Маргад нарыг дасгалжуулан амжилттай оролцож, Турк даамын төрлөөр 11-13 насны ангилалд сурагч Н.Орхонцэцэг оюун ухаанаа сорин

уралдаж 1-р байрт шалгарч алтан медалийн эзнээр тодорч Ази тивийн аварга боллоо.

Баян-Уулын тахилгын баярыг 6-р сарын 03-нд зохион байгуулж, хүчит 32 бөхийн барилдаан, их нас, дааганы уралдааныг зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоол “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 30-60 насны нийт 22 эмэгтэй багш ажилчдын судалгааг нарийвчлан гаргаж, сумын ЭМТ-д мэдээлэн умайн хүзүүний хавдар илрүүлэх эсийн шинжилгээ болон хөхний хавдар илрүүлэх үзлэгт 100 хувь хамрууллаа.

Орхонтуул сүм

Сумын Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж 2019 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд 6 дугаар сард дараах ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан байна.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд байгууллагын Байгуулагын архивын зааврын дагуу тооллого хийхэд нийт 412 хадгаламжийн нэгжийг тоологдож бүртгэл хөтлөн ажиллалаа. Мөн архивд хадгалагдаж байгаа байнга хадгалах архивын нэгжүүдийг хайрцагтай болгож хуучирсан баримтуудыг засч сэлбэн, хуудасны тоо хэтрүүлсэн баримтыг задалж стандартын дагуу үдэж хавтаслах ажлыг 6-р сарын 4-14-нийг өдрүүдэд зохион байгууллаа. Улсын үзлэгийн хүрээнд төр, төсвийн нийт 7 байгууллагын Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудыг хамруулсан сургалтыг 1 удаа зохион байгуулсан бөгөөд улсын үзлэгийн бэлтгэл ажилтай сумын ЗДТГ-н даргаар ахлуулсан ажлын хэсэг нийт 2 удаа байгууллага бүрээр явж танилцан үүрэг чиглэл өгч ажилласан байна.

Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг бүрдүүлэх ажлыг тайлант сард зохион байгуулж оны эхнээс гарсан 78 захирамж, 25 тушаалд Хувийн хэргийг нөхөн бүрдүүллээ. Тайлант сард захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гараагүй байна.

Тайлант сард иргэдээс сумын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт нийт 2 өргөдөл ирүүлсэн байна. Үүнээс ажил хүсэх тухай-1, мөнгөн тусламж хүсэх тухай-1 байна. Өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

Энэ сард төрөлт 4, гэрлэлт 2, нас баралт 2 бүртгэгдсэн байна. Шилжиж ирсэн 7 иргэн байна. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж “Шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үзүүлэх журам”-ыг тогтмолжуулан шинэ төрсөн 4 хүүхдэд хүндэтгэл үзүүллээ.

Нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч даатгуулагчдаас 6-р сарын 25-ны байдлаар 22838,4 мянган төгрөгийн шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 32 даатгуулагчаас 20396,1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд иргэдийг хамруулан 5 иргэнтэй гэрээг шинэчлэн байгуулсан ба шинээр малчин-1, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн-1 иргэнийг хамруулан 1676,7 мянган төгрөгийн орлогыг орууллаа. Тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь тавьж олгосон бөгөөд өндөр насны тэтгэвэрт 375 хүнд 116769.0 мянган төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 126 хүнд 26295.6 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 27 хүнд 6422.6 мянган төгрөг, цэргийн өндөр насны тэтгэвэр 3 хүнд 2102.1, цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр 1 хүнд 404.5 мянган төгрөг, нийт 151993.8 мянган төгрөгийг харилцагч банкуудаар тавьж олголоо.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд “Бичиг соёлын өв” үзэсгэлэн, “Зайрмагны баяр”, “Дугуйн уралдаан” болон “Хүүхдийн бөхийн барилдаан” зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Мөн “Шилдэг сурагч”-р 3 хүүхэд, “Авьяаслаг сурагч” 1 хүүхдийг шалгаруулан шагнаж урамшууллаа.

Хамтарсан багийн бүрэлдэхүүн хуралдаж 6-р сарын 9-нд гарсан ослын улмаас хүнд бэртэж гэмтсэн 10 настай У.Батзолбоод нөхцөл байдлын үнэлгээ хийж төр,

төсвийн байгууллагуудыг уриалан хандив цуглуулж эмчилгээний зардалд 417000 төгрөгийн тусламж дэмжлэг үзүүлээ.

Сумын ИТХ-ын 6-р сарын 16-ны хурлаар “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”, “Хүүхдийн амны хөндийн өвчлөлийг бууруулж, урьдчилан сэргийлэх хөтөлбөр”, “Гэр бүл хүүхэд залуусын хөгжлийг дэмжих сумын хөтөлбөр”-г шинэчлэн боловсруулж батлууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн нэг Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих малжуулах арга хэмжээнд залуу малчин Г.Батсайханы өрхийг хамруулж 5,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамруулж малжууллаа.

Сүхбаатар сум

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэдэх хууль зүйн бодлогын хорооны 01 тоот удирдамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг Сүхбаатар сумын сүм хийдүүдэд зөвлөн туслах хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Сүхбаатар сумын “Баянхан уул”-ыг тахиx овооны баяр наадмыг 2019 оны 6-р сарын 14-ний өдөр аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулж, хурдан морь, үндэсний бөх, үндэсний сурын харваа, шагайн харваа зэрэг үндэсний спортын тэмцээн уралдааныг зохион явууллаа.

Сумын Засаг даргын захирамжаар хагас жилийн малын түүвэр судалгааг 6 дугаар сарын 02-10-ны хооронд зохион байгуулж, 52 өрхийн 3887 мал, үүнээс адуу 743, үхэр 1205, хонь 794, ямаа 1145 тоологдсон. Мөн аймаг, сумын Засаг даргын захирамжийн дагуу “Бог малын ангилалтын ажлыг 1, 5-р багийн 6 өрхийн 945 толгой бог хийлээ.

“Багш, сурагч солилцоо” аймгийн хөтөлбөрийн хүрээнд сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нар Тайланд Улсын Банкок, Патая хотуудын боловсролын байгууллагын үйл ажиллагаатай тусгай хөтөлбөрийн дагуу танилцах уулзалтыг зохион байгууллаа.

Хүүхдийн баяр арга хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд сурлага, урлаг, спортоор онцгой амжилт гаргасан нийт 52 хүүхдийг Засаг даргын нэрэмжит шагналаар шагнаж урамшуулан 6-р сарын 1 өдөр төрсөн 38, ихэр төрсөн 203 хүүхдэд Засаг даргын бэлгийг гардуулж өглөө. Мөн алдарт эхийн одон, “Алдарт ээж” шагнал гардуулах хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгууллаа. Сумын Засаг даргын Тамгын газраас жил бүр зохион байгуулдаг “Халамж” арга хэмжээнд зорилтот өрх бүрээс 0-18 насны 133 хүүхдийг хамруулж усанд оруулан үсийг нь засуулжурлагын тоглолт үзүүлэн гарын бэлэг гэрээр тараан өглөө.

Монгол Улсын Засгийн газраас баталсан Биеийн тамир, спортын хөгжүүлэх бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Дугуйтай өдөрлөг”, “Йогийн өдөрлөг”-ийг зохион байгуулж, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/207 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2019 оны А/174 тоот захирамжийн дагуу дархлаажуулалтын 10 хоногийн аяныг өрнүүлж, “Улаанбурханд цэг тавья” уриан дор сумын 10-18 насны 2779 хүүхэд хамрагдлаа.

“Бэлчир бүс”-ийн “Дулаанхааны уянга” ардын уламжлалт урлаг, тоглоом наадгайн чуулга уулзалт Дулаанхаан тосгонд зохион байгуулагдсан ба Сүхбаатар сумын ахмадууд багийн нийлбэр дүнгээр тэргүүн байранд шалгарсан байна.

Засаг дарга болон сумын ажлын хэсэгтэй хамтран 2019 онд Сүхбаатар суманд Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа Сайхны хөтөлийн хатуу хучилттай 7 км хар зам, ган замын 7-р багийн нийтийн эзэмшлийн орон сууцнуудын инженерийн шугам сүлжээний засварын ажил, 3-р сургуулийн дээврийн засвар, Буурын голын тохижилтын ажил, шар байрнуудын орцны цонхыг вакуум болгох орцны гэрлүүдийг мэдрэмжтэй гэрлээр солих ажилд хяналт тавьж ажиллалаа.

Хушаат сум:

Хушаат сумын "Хушаатын Ургац" ТББ-аас Цагаан овооны тахилгын ёслолыг үйлдэн 32 бөхийн барилдаан, даганы уралдаан бүхий овооны наадмыг зохион байгуулжээ. Мөн эх үрсийн баяраар Ерөнхийлөгчийн зарлигаар Алдарт эхийн 1,2-р одон, УЗН-ийн "Энэрэл" алт, мөнгөн медалиар шагнаж урамшуулсан ба сумын Эмэгтэйчүүдийн холбоо, Монголын Гэр бүлийн холбоотой хамтран "Дархан бэр" "Уран бэр" цол өргөмжлөлийг 4 залуу ээжид олгох үйл ажиллагаа боллоо.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс "Алтан боломж" сургалтын төвтэй хамтран "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцааг хууль, эрх зүйн хүрээнд зохицуулсан байдал" сургалтыг зохион байгуулж 6 байгууллагын 27 хүн оролцсон.

Захирамжаар батлагдсан хуваарийн дагуу тус сард Татварын орлогын төлөвлөгөө 25191.0 сая төгрөг төлөвлөгдснөөс гүйцэтгэлнь 16171.0 буюу 83,7 хувийн биелэлттэй байна

"Мөнхтолгой" 2-р багийн хэмжээнд хагас жилийн малын тооллогын түүвэр судалгааг хийж дуусгасан. Малчид тариаланчдын зохицлыг хангах зорилгоор Төмс хүнсний ногоо, тариалангийн талбайг ма Багийн ИНХ-ыг хэсэгчилсэн байдлаар 4 чиглэлд хийсэн ба тариалангийн талбайд мал оруулахгүй байх тухай гурвалсан гэрээнд нэмэлт заалт оруулж гэрээг хөдөөгийн 70 малчин, сумын төвийн 25 мал бүхий иргэнтэй байгууллаа.

Энэ сард Хушаат сумын үе үеийн төгсөгчдийн дунд уламжлал болон зохиогддог Гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээн, УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатын санаачлагаа 6-р сарын 21-23-ны өдрүүдэд Орхон, Сэлэнгийн бүсийн боловсролын байгууллагын багш ажилчдын дунд ажил мэргэжлийн туршлага солилцсон сайхан үйл ажиллагаа зохион байгуулагдлаа.

"Хэнд ч Хаана ч" уриан дор Дэлхийн донорын өдрийг тохиолдуулан шинээр 20 донор элсүүлж урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан.

Энэ оны хаврын үр тарианы эцсийн мэдээгээр нийт эргэлтийн 22,4 мянган га тариалангийн талбайгаас 13,9 мянган га-д тариалалт хийн 8,5 мянган га-г уриншлахаар байна. Үр тариа 10,7 мянган га-д, тэжээлийн ургамал 153 га, гурвалжин будаа 387 га, техникийн ургамал 2335 га, буурцагт ургамал 35 га, ногоон тэжээл 246 га-д тариалаад байна. Төмс хүнсний ногоо ийтт 483,3 га-д тариалснаас төмс 245,1 га-д, хүнсний ногоо 238.2 га-д тариалсан байна.

Хүдэр сум:

Сумын Засаг даргын Тамгын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Хүлээж биш хүрч үйлчлье" аяны хүрээнд 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газрын чиглэлээр шинэчлэгдэн гарсан хууль тогтоомжийг танилцуулан газрын талаархи мэдээ зөвлөгөө өгч иргэдийн асуултанд хариулж үйлчилгээг үзүүлж ажиллалаа. Аймгийн БОАЖГ-ын "Хавар" нэгдсэн арга хэмжээний удирдамжийн хүрээнд сумын хэмжээнд "Хавар" нэгдсэн арга хэмжээний ажлын төлөвлөгөө гарган Сумын Засаг даргаар батлуулан ажиллаж, БОХУБайцаагч, Байгаль хамгаалагч, хэсгийн мөрдөгч нар хамтран төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг 2 удаа зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын албан даалгавар, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019.05.16-ны өдрийн 01/271 тоотын дагуу суманд хууль бусаар ашигт малтмал олборлож байгаа аж ахуй нэгжийн үйл ажиллагааг шалгах зөрчлийг таслан зогсоох, ажлын хэсэг байгуулагдан хяналт шалгалтыг 2 удаа хийж ажиллалаа.

Улаан бурханы вакцин 10-18 насны 300 гаруй хүүхэд хамрагдаж, "Сүрьеэгүй Сэлэнгэ" төслийн хүрээнд сургуулийн багш, ажилчид бүрэн хамрагдлаа.

Тайлант сард мэргэжлийн багш нар анги дэвших шалгалтын материал сурагчдаар ажиллуулан бэлдэж анги дэвших болон анги төгсөх шалгалтыг зохион байгуулсан.

Тарвагатай, Баянцагаан багийн иргэдийн нийтийн хурал, Дэлхийн зөнгийн сургалт, Аймгийн СДЧуулгын дуучин СТА Цолмон, “Эх үрсийн баяр”, “Дархан бэр” алдаршуулах үйл ажиллагаа, “Алтан овоо”-ны тахилгын баяр наадам, СТА Б.Отгонтогтохын аялан тоглолт, Ахмадын холбооны “Дуулах өдөр дуун цэнгүүн” арга хэмжээг тус тус зохион байгуулсан.

Хүүхдийн хөгжил, хүмүүжил хамгаалалын "Зөв тусгал" аянд төрийн албан хаагчид Цэцэрлэг, ЕБСургуулийн сурагчдын эцэг эхчүүд, зорилтот бүлгийн 15 өрхийн гишүүдэд сургалт, лекцүүдийг амжилттай зохион байгууллаа.

Жил бүрийн 6 дугаар сарын 1-нд болдог Олон улсын хүүхдийн баярын өдрийг угтан сумын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээр хамтарсан багийн гишүүд гэрээр нь бэлгийг нь хүргэж өглөө.

Аймаг, сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг малын хагас жилийн түүвэр судалгааг 6-р сарын 3-наас 10-ны хооронд явуулсан. Мөн сумын Засаг даргын захирамжийн дагуу “Марс нуга” хувийн мал эмнэлгийн үйлчилгээ сумын хэмжээнд Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 18700 толгой малд вакцинжуулалт хийсэн.

Зүүнбүрэн сум:

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат тойрогтоо ажиллан Монгол Улсын үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг ард иргэдэд танилцуулан санал авлаа.

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” уриа дор тэмдэглэн өнгөрүүллээ. Уг арга хэмжээний хүрээнд 14 дүгээр цэцэрлэгийн 3-5 насны хүүхдүүдийн дунд “Миний дуртай тоглоомууд” сэдэвт гар зургийн уралдаан, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд “Миний гэр бүл-Миний аз жаргал” эссэ бичлэгийн уралдаан, “Медиалиа зүүцгээе” тэргүүний сурагчдыг алдаршуулах сумын Засаг даргын нэрэмжит арга хэмжээг тус тус зохион байгуулж шалгарсан сурагчдыг дурсамж, гарын бэлгээр шагнаж урамшууллаа. Мөн хүүхдийн баярын урлагийн тоглолтонд оролцсон 90 гаруй сурагчдыг урамшууллаа.

Хөрсөөр дамжин халдварладаг мөөгөнцрийн гаралтай өвчнөөс урьдчилан сэргийлэх Пропамакс, бүх төрлийн тарималын навч идэгч шавьж, бөөс, ялааг устгадаг Имидаклоприд, төмсний хог ургамалтай тэмцэх Топ-120 бодисын талаар дэлгэрэнгүй заавар, зөвлөмжийг нийт 20 гаруй тариаланчдад өгсөн ба уг сургалтыг “Agrimatco” ХХК болон Доктор, профессор Б.Амаржаргал, УХЭШХ-ийн судлаач эрдэмтэн А.Уранчимэг нартай хамтран зохион байгууллаа.

Мал эмнэлгийн технологит үйлчилгээний чанарыг сайжруулахаар, МЭҮН, сумын Засаг дарга, мал бүхий өрхтэй, мал эмнэлгийн ажил үйлчилгээг хэрэгжүүлэх талаар 3 талт хариуцлагын гэрээ байгуулж, 514 өрхөөс 320 өрхтэй гэрээ байгуулан ажиллалаа. Малын халдварт өвчний эрсдэлтэй бүс нутгийн судалгааг 1998 оноос эхлэн гаргаж, 2020 онд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд улсын төсвийн санхүүжилтээс 23016, орон нутгийн санхүүжилтээс 21652, иргэн хуулийн этгээдээс 16900 толгой нийт 42568 толгой малыг хамруулах нэгдсэн захиалга гаргаж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүллээ.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төсөв, эдийн засаг, нийгмийн бодлогын ажлын хороо, сумын ГХУССЗ-тай хамтран худалаа, үйлчилгээний байгууллагад үзлэг шалгалтыг зохион байгууллаа. Үзлэг шалгалтаар бүртгэл хөтлөлт жигдээрээгүй, гадна орчноо камержуулаагүй, 11 ширхэг нийслэл пивоны хугацаа дуусан байсныг буцаан авалтанд, 1 хүнсний мухлаг ажлын байрын дүгнэлтгүй зэрэг дутагдал илрүүлж, дутагдлыг арилгаж ажиллах талаар хугацаатай үүрэг өгч ажиллалаа.

Жавхлант сум:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуралдаж 2019 эхний хагас жилийн үндсэн чиглэлийн биелэлт, төр төсвийн байгууллагуудын актлах эд хөрөнгө, сумын баяр наадмын тов тогтоох, татварын орлого бусад асуудлыг хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар иргэд сонгогчдод мэдээлэл өгөх, тэдний санал бодлыг сонсох зорилгоор УИХ-ын гишүүн Н.Оюундарь 6 дугаар сарын 23-нд суманд ажиллаж, Ерөө гол, Хүйтний голын малчид, сумын төвийн иргэдтэй уулзалт хийлээ.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-аас Орхон аймгийн ХААИС-ийн захирал доктор Н.Алтанцоожтой хамтран “Гэр бүлийн хандлага харилцаа” сэдэвт сургалтыг явууллаа.

Төр төсвийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэдс урталчлах, Атар газар эзэмшсэний 60 жилийн ойг тохиолдуулан газар тариалангийн аж ахуйн нэгжүүдийг сурталчлах, хамтын ажиллагааг сайжруулах, иргэдийг мэдээллээр хангах эерэг хандлагыг бий болгох зорилготой “БАЙГУУЛЛАГА СУРТАЛЧЛАХ” 14 хоногийн аяныг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор зохион байгуулагдсан Азийн ардын урлагийн их наадамд амжилттай оролцож, наадмын шагнал гардуулах ёслолын үеэр МУ-ын Засгийн газрын шагнал МУ-ын Тэргүүний ардын авъяастан, цол тэмдгээр ардын авъяастан Н.Хишгээсүрэн, хөгжмийн багш Б.Баттулга нар шагнагдлаа.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжиж Моностой 2-р багийн малчин А.Нурболат, Л.Мөнхбаяр, Ц.Хуланхүү, П.Батбаяр, Д.Баатар нар хамрагдаж малчин өрхүүдэд 4500,0-5000,0 төгрөгийн мал худалдан авч өгч малжууллаа.

Цагааннуур сум:

Олон улсын хүүхдийн эрхийг хамаалах өдөр, эх үрсийн баярын арга хэмжээг “Хамгаалагдсан хүүхэд, Хариуцлагатай гэр бүл” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн ба Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 5-Р сарын 23-ны өдрийн 94 тоот зарлигаар 24 эх “Эхийн алдар” хоёрдугаар одонгоор, 2 эх “Эхийн алдар” нэгдүгээр одонгоор шагнагдсаныг гардуулан өгсөн.

Монгол Улсад атар газар эзэмшсэний 60 жилийн ойн арга хэмжээний нээлтийг 6-р сарын 4-нд зохион байгуулж, хүчит бөхийн барилдаан, хурдан морины уралдааныг явууллаа.

Монгол оронд “Хангай” үүлдрийн хонь өсгөн үржүүлж эхэлсэний түүхт 60 жилийн ойн баяр наадам 6-р сарын 17-18-ны өдрүүдэд болж, Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн гишүүдтэй суманд үржүүлж буй “Хангай” үүлдрийн хонинд ангилалт үзлэг явуулж, хувьсын болон ангийн ангталалтын үзүүлэлтүүдийг боловсруулан дүн мэдээг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

“Шинэ бадрах” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд 6-р сарын 09-14 хүртэл хугацаанд Оргих 1-р багийн Шүрэнгийн голд Төрийн үйлчилгээ явуулах байрыг барьж хүлээлгэн өгсөн.

Сургуулийн өмнөх боловсролыг хүүхдэд хүргэх үүднээс хувилбарт цэцэрлэгийг сумын төвөөс алслагдсан Шүрэнгийн голд 2 бүлгийг ажиллуулж, 75 хүүхдийг хамрууллаа.

ХЯНАСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА